ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 03 сард)

2018.04.12

www.nso.mn

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД



1040



353

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд



Өмнөх оны мөн үе

40.6%

Өмнөх Сараас

344



43 иргэн ажилд зуучлагдан оржээ

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 3 сарын эцэст 696 болсны 687 (98.9%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 9 (1.3%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Нийт ажилгүй иргэдийн 353 (50.7 %) нь эмэгтэйчүүд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 1015(59.3%) хүнээр буурч, өмнөх сараас 344(33.1%) хүнээр өссөн байна.

Хөдөлмөрийн хэлтэст 2018 оны эхний 03 сард 1005 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 58 иргэн ажилд зуучлагдан орж, 697 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Бүртгэлтэй ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр, 2018 оны 03 сард



ЭРҮҮЛ МЭНД

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 03 сард 352 эх амаржиж, 352 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 46(15.0%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 44(14.3%)-өөр, 90 хүн нас барсан нь 7(8.4%)-аар тус тус өссөн байна.

Нялхсын эндэгдэл 4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 33.3 хувир буурчээ.

Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй

Халдварт өвчний 147 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 160(52.1%)-аар буурчээ.

Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 17.9 хувь, трихомониаз 64.3 хувь, вирус гепатит 66.7 хувь , бусад төрлийн өвчин 77.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ЭРҮҮЛ МЭНД

Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 03 сард



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 03 сард 8107.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1475.6 (22.2%) сая төгрөгөөр өссөн байна.

02

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 03 сард өмнөх оны мөн үеэс 1475.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1009.9(24.7%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 169.1(25.0%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 134.1(11.0%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

03

Нийгмийн даатгалын сангийн зарлага 11448.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2285.1 (24.9%) сая.төгрөгөөр өссөн байна.

04

Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 7749.2(67.7%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2438.9(21.3%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 601.6(5.3%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 485.4(4.2%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 172.9(1.5%) сая төгрөгийг зарцуулжээ.

05

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 03 сард нийгмийн халамжийн сангаас 18866 иргэнд 2327.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн цагаар





Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 03 сарын байдлаар 144 хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 52(22.2%)-оор буурсан байна.

Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэрэг буурахад хүний амины гэмт хэрэг 9(75.0%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15(65.2%)-аар, дээрмийн гэмт хэрэг 1(50.0%)-ээр хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 16 (33.3%)-аар буурсан нь голлон нөлөөлөв.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 172.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 834.5(82.9) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 47.6(27.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

мөнгө, зээл

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг

2017 I-III	2018 I-III
63953.5	82201.1

Зээлийн өрийн үлдэгдэл, сая.төг

2017 I-III	2018 I-III
186943.1	215431.0

-Иргэдийн мөнгөн хадгаламж 82.2 тэрбум төгрөг болж
18.2 тэрбум ⬆

- Нэг хадгаламж эзэмшигчдэд 1214.3 мянган төгрөг
255.5 мян.төг ⬆

- Нэг хүнд дундажаар 1205.3 мянган төгрөг болж
245.0 мян.төг ⬆

- Хадгаламж эзэмшигчийн тоо 67.7 мянган хүн болж
1.0 % ⬆

-Зээлдэгчийн тоо 29.6 мянган хүн болж
2.1 % ⬆

- Зээлийн өрийн үлдэгдэл 215.3 тэрбум болж
28.5% ⬆

МӨНГӨ, ЗЭЭЛ

ЗЭЭЛ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.03-р сард



Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.03-р сард



ТӨСӨВ, САНХҮҮ

2018 оны 03 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 7133.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 119.6 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 35.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 64.0 хувийг татварын, 36.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого, сая төг

5259.4 — 2017 I-III

7133.6 — 2018 I-III



Орон нутгийн төсвийн зарлага, сая төг

11772.7 — 2017 I-III

12798.1 — 2018 I-III

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 03-р сард өмнөх сараас 1.3 хувиар өсч, харин өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 03 дугаар сард өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа усны бүлэг 4.1 хувь, хувцас бөс бараа,гуталын бүлэг 0.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.3 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа усны бүлэг 6.0 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 6.9 эм,тариа, эмнэлэгийн үйлчилгээ 18.9 хувь, тээврын бүлэг 13.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа 10.2 хувиар нэмэгдсэн байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Бойжиж буй төлийн тоо, 2015-2017 оны 3-р сарын байдлаар, толгой

	2015.I-III	2016.I-III	2017.I-III	2018.I-III
Бүгд	124839	106242	98745	180562
Ботго	1036	597	369	2073
Унага	692	359	579	1000
Тугал	1854	1027	1090	1583
Хурга	67278	57941	60630	100368
Ишиг	53979	46318	100368	75538

Том малын зүй бус хорогдол, 2015-2017 оны 3-р сарын байдлаар, толгой



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний 03 сард 28965.7 сая төгрөг төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13735.4 (190.2%) төгрөгөөр өслөө.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2018 оны эхний 03 сард 37617.7 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 6159(19.6%) төгрөгөөр өслөө.

АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт салбараар



Аж үйлдвэрийн нийт борлуулалт салбараар



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, дэд салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	2016 I-III	2017 I-III	2018 I-III	2017 I-III / 2018 I-III
	сая.төг			хувь
Дүн	4904.6	15230.3	28965.7	190.2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	333.6	10018.2	16260.8	162.3
Нүүрс олборлолт	333.6	10018.2	16260.8	162.3
Бусад ашигт малтмал олборлолт				
Боловсруулах аж үйлдвэр	268.3	2256.1	10210.6	2.3²
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	207.8	858.9	434.8	50.6
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.6	652.5	252.0	38.6
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	23.8	50.0	49.1	98.2
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	175.4	156.9	133.7	85.2
Хувцас үйлдвэрлэл	20.5	12.2	20.6	168.9
Гутал үйлдвэрлэл	5.8	8.0	2.1	26.3
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	9.1	12.0	21.5	2.3²
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.1	0.3		
Боловсруулах үйлдвэрийн бусад	25.0	1364.7	9731.6	7.1²
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	4302.7	2956.0	2494.3	84.4
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	3832.7	2205.2	2055.9	93.2
Ус ариутгал, усан хангамж	470.0	750.8	438.4	58.4

ТЭЭВЭР

01 Оны эхний 3-р сарын байдлаар ачаа эргэлт 12909.4 мян.тн.км байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 104.6 (0.8 %) нэмэгдсэн байна

02 Тээсэн ачаа 19.2 мян.тн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 25.1 (56.6%) буурсан байна

03 Оны эхний 3-р сарын байдлаар зорчигч эргэлт 2064.0 мян.хүн.км байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 828.3 (67%) нэмэгдсэн байна

04 2018 оны 03-р сарын байдлаар зорчигчын тоо 14.2 мян.хүн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 8.2 (36.6%) буурсан байна

05 Тээврийн салбарын орлого 2596.1 сая төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 75.4 (2.8%)-аар буурсан байна

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистикийн лавлах
1900-1212

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
www.1212.mn

Дорноговь аймгын Нутгийн удирдлагын ордоны 106 тоот

Статистик мэдээлэл

@statistic_mn

www.nso.mn сайтын **Хэрэглэгчийн бүртгэлд** бүртгүүлж мэдээлэл авах